

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
16-р хороо, Амарсанаагийн гудамж, 12-1
Колорадо бизнес төв, 1 давхар, 101 тоот
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2019.02.02 дугаар 19-VB2/04/56

таний _____ -ны дугаар _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**Дүгнэлт**

Бид **"МОНГОЛ ДИЗЕЛЬ" ХК** ('Компани' гэх)-ийн 2018 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт('СТОУС')-уудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт('АОУС')-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёсүйн олон улсын стандартын зөвлөл(НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёсүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёсүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёсүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

МОНГОЛ ДИЗЕЛЬ ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
Хараат бус аудиторын тайлангийн үргэлжлэл...

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээсэн аудиторын үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн www.magicgroup.mn вэб сайтанд оруулсан. Уг тодорхойлолт нь манай аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "**МОНГОЛ ДИЗЕЛЬ**" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.


С.Мөнхбаяр
Мэргэшсэн нягтлан бодогч, Партер
Мэжик Консалтинг Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2019 оны 02 сарын 02